



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/03

Сангивчлалыг

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 45 дугаар зүйлийн 45.3 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 11 дүгээр зүйлийн 11.1, 12 дугаар зүйлийн 12.1-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 2023 онд хийгдэх "Наадмын талбайн тохижилт" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Г.Энхдэлгэр (Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: С.Нямаа (Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
нарийн бичгийн дарга)

Гишүүдэд: Б.Өнөрбилэг (Олон нийт, хэвлэл мэдээлэл
хариуцсан ажилтан)

Т.Энхбат (Тусгай сан хариуцсан нягтлан бодогч)

Э.Бат-Амьдрал (Иргэний төлөөлөл)

2. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхолын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх, сонгон шалгаруулалтыг хуулийн хүрээнд зохион байгуулж, баримт бичгийн бүрдлийг хангаж архивт хүлээлгэн өгөхийг дарга гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ЛХАГВАМАНДАЛ



1923720005